



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/А


Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Төсөв батлах тухай” 2018 оны 20/17 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Эрх шилжүүлэх тухай” А/55 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Эрх шилжүүлэх тухай” А/55 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан “Мод сөөг хэлбэржүүлэх зориулалтаар бага оврын авто өргөгчтэй машин /автовиска/ 3 ширхэгийн нийлүүлэх”, “Мод сөөг хэлбэржүүлэх зориулалттай 7 төрлийн гар багаж 5 иж бүрдлийг нийлүүлэх” Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Дээрхи ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажиллахыг Үнэлгээний хороо /Г.Ууганбаяр/-д үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  С.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2019 оны 02 сарын 22 өдрийн  
НЗМ... тушаалын хавсралт



### ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Г.Ууганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд	М.Гансэлэм	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Л.Баатарцогт	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Т.Мөнхнасан	Сүхбаатар дүүргийн 3 дугаар хорооны иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Д.Нааяа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн